

Хөдөлгөөнгүй байна гэдэг нь аюулгүй гэсэн үг биш.

2022 оны 11 сар



Зураг 1: Будгийн үйлдвэр дэлбэрэлтийн дараа



Зураг 2: Будгийн үйлдвэр дэлбэрэлтийн өмнө

2006 оны 11 сарын 22-ны өглөөний 2 цаг 45 минутад Массачусеттс мужийн Дэнверс хотод асар хүчтэй дэлбэрэлт болсон. Дэлбэрэлтийн улмаас бэх болон будаг үйлдвэрлэх байгууламж сүйрч (Зураг 1), ойролцоох орон сууцны болон бизнесийн барилгууд нурж, зарим цонхны шил 3.2 км хүртэлх зайд шидэгдсэн. Ослын өмнөх өдөр буюу 11 сарын 21-ний 13:00 цагт ажилчид 2000 галлоны хэмжээтэй, шатамхай бодис бүхий зуурмаг холих ажлыг эхлүүлжээ. 15:00 цагийн үед үйлдвэрлэлийн менежер хольцыг 32°C хүртэл халаах зорилгоор уурын хавхлагыг нээсэн. 17:00 цагт менежерийг буцаж ирэхэд хольц 32°C хүртэл халсан байсан ба тэрбээр уусаагүй давирхайг тунахаас сэргийлэхийн тулд холигчийг асаалттай орхиж явсан. 18:00 цагт сүүлийн ажилтан тоос сорогчийн сэнс, агаар зайлуулах болон цэвэр агаар сэлгэх сэнснүүдийг унтраасны дараа байшинг цоожилж явсан. Танкны халаалт үргэлжилсэн хэвээр байсан тул түүнээс үүссэн шатамхай хий агаар сэлгэх системийг унтрааснаас хойш байшин дотор хуримтлагдсан бөгөөд өглөөний 2 цаг 46 минутад дэлбэрэлт болсон. Албаны хүмүүс ослын газрын ойролцоох 300 орчим оршин суугч, 10 бизнесийн байгууллагыг нүүлгэн шилжүүлэх үүрэг өгсөн. (Эх сурвалж: CSB Report N. 2007-03-I-MA, May 2008)

Дэлхийн олон оронд жилийн эцсээр баяр наадам тэмдэглэдэг. Зарим үйлдвэр хөрөнгийн нөөцийг багасгах эсвэл ажилчдыг амрахын тулд үйл ажиллагаагаа түр зогсоодог. Энэ нь үйлдвэрийн аль нэг хэсэгт үйл ажиллагаа нь зогссон хэдий ч дээрх осолтой адил танк саванд аюултай материал хадгалагдсан хэвээр байх нөхцлийг бүрдүүлдэг.

Та мэдэх үү?

- Үйлдвэрийн материалуудыг зориулалтын саванд хадгалж байгаа тохиолдолд ч найрлагын хувьд аюултай хэвээр байдаг.
- Тоног төхөөрөмжийг унтраасан эсвэл хөдөлгөөнгүй горимд шилжүүлсэн үед ч хяналт болон дохиоллыг идэвхжүүлэх хэрэгтэй.
- Үйлдвэрийн тоног төхөөрөмж дотор хадгалагдаж буй урвалд идэвхтэй бодисууд урвалд орох температурын заалтаас доош хэмд ч урвалд орсон хэвээр байж болзошгүй. Тэдгээрийг хамгийн аюулгүй цэгт хадгал.
- Тоног төхөөрөмжийг унтраасан үед ч хавхлага шүүрэх, процессын шугамыг нээлттэй орхиж зэрэг янз бүрийн өөрчлөлт тохиолдож болно.
- Үйлдвэрийн засвар үйлчилгээг сул зогсолттой үеийг ашиглан гүйцэтгэж болох ч энэ нь тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн процесст өөрчлөлт учруулж болзошгүй.
- Ажилчид баяр ёслолоор амрах үед ажилчдын тоо цөөрч, зарим ажилчид удаан хийгээгүй ажлаа хийх шаардлага үүсч магадгүй.
- “Баярын уур амьсгал” үйлдвэрийн ажилтнуудыг ажлаас нь сатааруулж болзошгүй.

Та юу хийж болох вэ?

- Тоног төхөөрөмжийг унтраасан эсвэл хөдөлгөөнгүй горимд шилжүүлсэн үед ч хяналт болон дохиоллыг идэвхжүүл.
- Тойрох үзлэг хийхдээ тоног төхөөрөмж бүрэн хүч чадлаараа ажилладаг үеийнхтэй адил түвшинд гүйцэтгэж, бүх зүйл аюулгүй байгаа эсэхийг нягтал.
- Хэрэв тоног төхөөрөмж дотор үйлдвэрийн материал үлдсэн бол тухайн материал болон үлдэгдэл нөөцийн тухай ээлжийн тайланд тэмдэглэж бич.
- Тоног төхөөрөмжийг хоослох үед нээгддэг шавхах хоолой болон гаралтуудыг бүрэн хааж, бүх хаалт, таглааг буцааж угсарсан эсэхийг давтан шалгаж баталгаажуул.
- Хэрэв та ойрд хийгээгүй ажлаа хийх даалгавар авсан бол дүрэм журамтай нь бүрэн танилцахад цаг зарцуул. Таныг тус ажлыг хамгийн сүүлд хийснээс хойш гүйцэтгэх алхам эсвэл ХХХ-ийн заалтуудад өөрчлөлт орсон эсэхийг шалга.
- Өөрийгөө болон бусдыг баяр ёслолын уур амьсгалд сатаарахаас сэргийл. Ажилдаа анхаарлаа төвлөрүүлж, баяр ёслолыг дараа нь тэмдэглэ.

Баяр наадмын үед үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханга.